



НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Засгийн газрын 2021 оны "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/1038, 2021 оны "Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай" А/1059 дүгээр захирамж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам" 03, 2022 оны "Зөвшөөрөл олгох тухай" 349, 350 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зөвлөлөөс олгосон зөвшөөрлийн дагуу Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Тайлан мэдээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Аудит, хяналт шалгалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн /Ахлах дотоод аудитор/-ий албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Мэдээллийн технологи, шилэн данс хариуцсан дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Аудит, хяналт шалгалтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Аудит, хяналт шалгалтын хэлтсийн Ахлах дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар хавсралт хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан байгууллагын даргын 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн А/14 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс /Г.Шүрэнцэцэг/-т даалгасугай.

ДАРГА

Б.ЖАВЗАН



115000 106



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 360 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Дотоод аудитын албаны Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Тайлан мэдээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Аудит, хяналт шалгалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн /Ахлах дотоод аудитор/-ий албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Мэдээллийн технологи, шилэн данс хариуцсан дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Нийслэлийн Дотоод аудитын албаны даргад зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Дотоод аудитын албаны дарга (Б.Жавзан)-д үүрэг болгосугай.

3. Хянаж нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-нд даалгасугай.

4. Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх Салбар зөвлөл (Т.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

2201-413



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 360 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Дотоод аудитын албаны Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Аудит, хяналт шалгалтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Ахлах дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Нийслэлийн Дотоод аудитын албаны даргад зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Дотоод аудитын албаны дарга (Б.Жавзан)-д үүрэг болгосугай.

3. Хянаж нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-нд даалгасугай.

4. Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх Салбар зөвлөл (Т.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 107 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

2203-415